

МУЗЕЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь музейн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, музейн сан хөмрөг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Музейн хууль тогтоомж

2.1.Музейн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

[/2021-08-03 нэмэлт өөрчлөлт оруулсан /](#)

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт музейн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй үйлчилнэ.

[/2021-08-03 нэмэлт өөрчлөлт оруулсан дааа /](#)

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн галерейн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."музей" гэж соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллагыг;

4.1.2."музейн үзэл баримтлал" гэж музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүлэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.3."ерөнхий бүртгэл" гэж үзмэрийн хувийн дугаар, нэр, тоо, хэмжээ, тодорхойлолт бүхий бүртгэл, мэдээллийн баримт бичгийг;

4.1.4."үзмэр" гэж ерөнхий бүртгэлд бүртгэгдсэн музейн өмчийн соёлын үнэт зүйлийг;

4.1.5."цуглуулга" гэж нэг болон хэд хэдэн шинжээрээ харилцан холбоотой, тодорхой цаг үеийг төлөөлөх шинжлэх ухаан, урлаг, танин мэдэхүйн ач холбогдолтой үзмэрийн бүрдэл хэсгийг;

4.1.6."музейн сан хөмрөг" гэж үзмэр, цуглуулга, түүний хадгалалт хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн орон зайг;

4.1.7."үзүүлэл" гэж үзмэр, цуглуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны аргаар дэглэн үзүүлсэн орон зайг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5 дугаар зүйл.Музей байгуулах

5.1.Музейг төрийн болон орон нутгийн, хувийн өмчийн хэлбэрээр Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байгуулна.

5.2.Музейн үзэл баримтлалыг үүсгэн байгуулагч нь батлах бөгөөд орон нутгийн болон хувийн өмчийн музейн үзэл баримтлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөнө.

5.3.Музейн үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.

- 5.4.Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
- 5.5.Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг найман жилийн хугацаатайгаар олгоно.
- 5.6.Тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 5.7.Музейн дүрэмд заасан бол музейн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон нийтийн зөвлөл ажиллаж болно. Зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6 дугаар зүйл Музейн зэрэглэл

- 6.1.Засгийн газар Төрийн өмчийн музейд үндэсний, улсын, бүс нутгийн зэрэглэл тогтооно.
- 6.2.Үндэсний музей нь төрөл, үйл ажиллагааны чиглэлээр бусад музейг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.
- 6.3.Үндэсний болон улсын зэрэглэлийн музей төрийн хамгаалалтад байна.
- 6.4.Аймаг, нийслэлийн болон сумын музей орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах болон түгээн дэлгэрүүлэх чиг үүрэгтэй байна.

7 дугаар зүйл Музейн үйл ажиллагааны чиглэл

- 7.1.Музей нь үзэл баримтлалын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ:
- 7.1.1.соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, олж авах;
 - 7.1.2.үзмэрийг бүртгэх, баримтжуулах, музейн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - 7.1.3.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - 7.1.4.үзүүлэлг дэглэх, үйлчлэх;
 - 7.1.5.гадаад, дотоодод үзэсгэлэн зохион байгуулах;
 - 7.1.6.боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах;
 - 7.1.7.сургалт зохион байгуулах;
 - 7.1.8.эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх;
 - 7.1.9.гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
 - 7.1.10.үзмэрийг гадаад, дотоодын үзэсгэлэнд оролцуулах;
 - 7.1.11.иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн соёлын үнэт зүйлийг түр хугацаагаар үзэсгэлэн, үзүүлэлт дэглэж ашиглах;
 - 7.1.12.музей хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
 - 7.1.13.хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.
- 7.2.Музей нь Төсвийн тухай хуульд нийцүүлэн худалдаа, үйлчилгээ эрхэлж болно.
- 7.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дөрвөн жил тутам хараат бус хуулийн этгээдээр үнэлгээ хийлгэнэ.
- 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээ хийх аргачлал, үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуурыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 7.5.Аймаг,нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээний тайланг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
- 7.6.Музейн үүсгэн байгуулагч музейн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг санхүүжүүлэх үүрэгтэй.
- 7.7.Музей нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс хуулийн хүрээнд хандив, тусламж авч болох бөгөөд зарцуулалт, тайлагналт нь ил тод, нээлттэй байна.
- 7.8.Музейн санхүүжилт, хандив тусламжийн эх үүсвэр нь хуульд нийцсэн байна.
- 7.9.Соёлын өвд хамаарах үзмэрийг судлах, сурталчлах зорилгоор музей хооронд түр солилцох асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1-д заасны дагуу зохицуулна.

8 дугаар зүйл Музейн үзүүлэлг, дэглэлт

- 8.1.Музей нь үзмэр, цуглуулгыг эргэлтэд оруулах, мэдлэг мэдээлэл түгээх, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор үзүүлэлг, дэглэлтийг байнга шинэчлэх зарчим баримтална.
- 8.2.Музей нь үзэл баримтлалын хүрээнд зургаан жил тутам үзүүлэлг, дэглэлтээ шинэчлэх төлөвлөгөөний төслийг боловсруулна.
- 8.3.Төрийн өмчийн музейн үзүүлэлг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчийн музейн үзүүлэлг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн